



GS1 логистикийн шошгожуулалтын талаар Та бүхэн хир зэрэг мэдэх бол? Түүний давуу тал болоод үр ашиг нь юу вэ? Бид GS1 логистикийн шошгуудын талаар цуврал зовломжвудийг танилцуулж байна.

Энэ нь тээвэрлэлт болон агуулахын янз бүрийн шошгуудын танилцуулга бөгөөд энэхүү мэдээлэл, зовломжвудээр дамжуулан тээвэрлэлт, агуулахын үйл ажиллагааны стандартыг сайжруулах, процессыг ижилсүүлэх, тээвэр, логистик, агуулахын үйл ажиллагаанд оролцогч талуудын хамтын ажиллагааг хөгжүүлэх, нэгдсэн нэг стандартыг хэрэгжүүлэх боломжийг олгох болно. Оноодор логистикийн үйлчилгээ үзүүлэгчид болон тээвэрлэгчид хэрэглэгчдийн бараа бүтээгдэхүүний нийлүүлэлтийн сувагт жижиглэн худалдаачид, үйлдвэрлэгчид, материал нийлүүлэгчдийн орноос бараа бүтээгдэхүүний дотоод, гадаад урсгалыг удирдах, зохицуулахад чухал үүргийг гүйцэтгэж байна. Иймээс дээрх сэдэв нь Та бүхэнд олон талын сонирхолтой мэдлэг, мэдээллийг огно гэдэгт найдаж байна.

“Логистикийн шошго” гэдэг нь нийлүүлэлтийн гинжин сувгийн бүх оролцогчдод зориулагдсан глобал стандарт юм. Энэ нь нийлүүлэлтийн гинжин сувгаар дамжин онгорч буй логистикийн нэгжвудийг дахин дахин шошгожуулахгүйгээр зөвхөн цор ганц логистикийн шошго ашиглах давуу талыг олгож байдаг.

GS1 логистикийн шошго нь илгээх цэгээс хүрэх газар хүртэл бараа бүтээгдэхүүний тээвэрлэлтийн бүх үеийн туршид хэрэглэгдэх бүхий л мэдээллийг агуулдаг. Шошго нь нийлүүлэлтийн гинжин сувагт оролцогч талуудын олон тооны хэрэгцээ шаардлагуудад

хариулт огохийн зэрэгцээ бараа бүтээгдэхүүний биет урсгал болон мэдээллийн урсгалын хоорондын зохицол, ижилсүүлэлт, холбоо хэлхээг баталгаажуулдаг.



- SSCC /Serial shipping container code/ тээврийн серийн дугаар

SSCC тээврийн серийн дугаар нь логистикийн нэгжийн цор ганц таних тэмдэглэгээ юм. “

Логистикийн нэгж”

гэдэг нь тээвэрлэлт болон түгээлтэнд хэрэглэгдэхэд зориулагдан бүтээгдсэн эд зүйлс богоод түүний нэг жишээ нь бидний сайн мэдэх ачамаг, подон, хавтан, контейнар гэх мэтийг дурдаж болно. GS1 логистикийн шошгуудыг ашигласнаар хэрэглэгчид нийлүүлэлтийн гинжин сувгаар дамжин онгорч буй логистикийн нэгжүүдийг цор ганц таних тэмдэглэгээгээр таньж тодорхойлон, мордон мошгих, хянах боломжтой болно. Логистикийн нэгж бүр цор ганц таних тэмдэглэгээ буюу SSCC тээврийн серийн дугаартай байх богоод энэ дугаараар дамжуулан дундын агуулах, тээвэрлэлтийн зам, автоматжуулсан хүлээн авах цэгүүд дээр логистикийн нэгжүүдийг хялбархан таних боломжтой болох юм.

Түүнчлэн шуудангийн код, ачааны дугаар, байршлын глобал дугаар зэргийг логистикийн шошгоос харах боломжтой. Бидний дээр өгүүлсэн SSCC тээврийн серийн дугаар нь логистикийн шошгонд заавал байх цор ганц мэдээлэл богоод логистикийн нэгжүүдийг эзэмшиж байгаа компаниуд тухайн SSCC тээврийн серийн дугаарыг үүсгэнэ. Ихэнхи тохиолдолд компани оорийн компаний угтвар дугаарыг ашиглан SSCC тээврийн серийн дугаарыг үүсгэх нь хамгийн зов алхам юм. Хэрэв нийлүүлэлтийн сувгийн эхний дамжлага дээр хүлээн авсан логистикийн нэгж нь SSCC тээврийн серийн дугааргүй байвал тухайн нийлүүлэлтийн сувагт оролцож байгаа дараагийн этгээд нь SSCC кодыг хүлээн авсан логистикийн нэгжүүдэд хуваарилна. Дараагийн этгээд гэдэгт ачаа илгээгч, тээвэрлэгч, тээвэр зууч, логистикийн үйлчилгээ үзүүлэгч зэргийг дурдаж болно. Логистикийн нэгж бүр оорийн цор ганц, дахин давтагдашгүй SSCC кодтой байх ёстой. Тухайн логистикийн нэгж нь нэг ижил SSCC кодтой нэг буюу түүнээс олон тооны шошготой байж болно, учир нь нийлүүлэлтийн хэлхээний оорт хамаарах цэг бүрт тухайн шошгууд уншигдана. Харин нэг ижил торлийн логистикийн нэгжүүд оор оор SSCC кодтой байна. Учир нь SSCC кодын зарчим нь цор ганц, дахин давтагдахгүйд оршдог. SSCC код анх зохиогдсноос хойш жилийн дараа дахин ашиглагдах боломжтой.

From	DE40219	
E Dantès 135, rue du général Leclerc FR-92131 Issy les Moulineaux		
To		
Mustermann Gmbh Immermannstrasse 156 DE-40219 Düsseldorf		
Carrier	Speed Transport Ltd	Fresh Service
Delivery Date (YYYY-MM-DD)	Order number	Gross Weight (kg)
2007-05-22	AC 239	430
Ship to post	27640219	
SSCC	034531200000002527	
		
(421) 27640219		
		
(00) 034531200000002527		

GS1 Логистикийн шошгожуулалт
Зурагтай код, полилогистикийн шошгожуулалт, үүсгэсэн бөгөөд дэлгэрэнгүй мэдээллийг олохыг зорьж байна.